



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 6/07

Чингис хот

Д.Баттулгыг туршилтын
хугацаагаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай", 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтнээр Довжоо овогтой Баттулгыг 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн туршилтын 6 сарын хугацаагаар томилсугай.

2. Д.Баттулгын цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 509948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найм/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Баттулгад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР